ӨМНӨГОВЬ АЙМАГ
СЭВРЭЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 08 сарын 18 өдөр Дугаар 4/04 Сайншанд

Орон нутгийн хөгжлийн сангийн хяналтын хороо шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын 3 дугаар зүйлийн 3.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх Орон нутгийн хөгжлийн сангийн хяналтын хороог доорх бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Хорооны дарга: Ёс зүйн хорооны дарга
Гишүүдэд: Нийгмийн бодлогын хөгжлийн хорооны дарга
Эдийн засаг, өмч, төсөв санхүү, дэд бүтцийн хөгжлийн хорооны дарга
Байгаль орчин, аялал жуулчлал, хөдөө аж ахуйн хөгжлийн хорооны дарга
Ахамдын хорооны дарга

2. Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Хяналтын хороог удирдан зохион байгуулж ажиллахыг хорооны даргад, хорооны ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэн шаардлагатай шатахуун, бичиг хэргийн зардлаар хангаж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга (Ш.Одмаа)-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 7/08 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Ч.ОГТБИШ

4025013043